

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТҮҮВРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга		№	Зүйл, заалт	Хариуцах байгууллага	Биелэлт	Дүн
	1	2					
5	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд	1	6	1.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, шуурхай, гүйцэд эцэслэн шийдвэрлэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага нарт;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нар	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн 2025 оны жилийн төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хоног 2024 оны мөн үетэй харьцуулахад дундаж хугацаа 12 хоног 10 цаг 46 минут байсан бол 2025 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар 11 хоног 12 цаг 13 минут болж буурсан үзүүлэлттэй байна. 2025 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар иргэдээс тус газарт нийт 1423 өргөдөл, гомдол, хүсэлт ирснийг 1372 өргөдөлд буюу 96%-тай шийдвэрлээд байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад (93%) шийдвэрлэлт 3 хувиар өссөн байна. Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ 961 гомдлыг иргэний талд, 410 өргөдөлд боломжгүй тухай хариу өгсөн бөгөөд албан бичгээр 370, утсаар-788, 102 иргэнд мессеж буюу цахим харилцаагаар хариуг хүргүүлж, 112 иргэнтэй биечлэн уулзаж шийдвэрлэсэн байна. Нийт зөрчил давхардсан тоогоор 139 байгаа бөгөөд өнгөрсөн онд 508 зөрчилтэй байсан бөгөөд мөн үеэс	80

						369 зөрчлөөр эрс буурсан үзүүлэлттэй байна. 1. Явцын тэмдэглэл хөтлөөгүй-64 2. Өдөрт нь багтаан хүлээн аваагүй-29 3. Өдөрт нь багтаан шилжүүлээгүй-45 4. Буцаалтыг 3 хоногт хийгээгүй-1 Байгууллагын дотоод сүлжээнд зөрчил гаргасан мэргэжилтний нэрсийг зарлаж хэлтсийн дарга нарт сануулж, мэргэжилтэн тус бүрээс тайлбар авч Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд Өргөдөл гомдлын 7 хоногийн тайлангийн хамт хүргүүлэн ажиллаж байна.	
		2	7	7.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдол болон хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг харгалзан үзэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нар	Нийслэлийн Эрүүл мэндийн газар нь албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэхдээ иргэдийн өргөдөл, гомдол болон хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг хэрхэн, яаж, хэдэн хоног шийдвэрлэсэн эсэхэд дүн шинжилгээ хийж, анхаарал хандуулан ажиллаж байна.	100
8	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд:	1	32	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн удирдлагыг өөрчлөх асуудлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (П.Эрхэмбулган), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан), тухайн байгууллагын эзэмшиж байгаа нийслэлийн өмчийн барилга, байгууламжийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус үүрэг болгов” гэжээ.	Нийслэлийн Эрүүл мэндийн газар Нийслэлийн Өмчийн харилцааны газар	Нийслэлийн Засаг Даргын 2025 оны “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэгтгэсэнтэй холбоотой авах зарим арга хэмжээ тухай” А/824 дүгээр захирамжийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төвийн бүртгэлтэй эд хөрөнгийг Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн балансаас балансад шилжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран тус дүүргийн УАУЭСК төв болон Хан-Уул дүүргийн “Богд-Уул” сувиллын эд хөрөнгийг тоолж бүртгэх ажлыг 2025	80%

					оны 07 дугаар сарын 07-ны өдөр бүрэн дуусгасан. 2. Актлах шаардлагатай хөрөнгө болон балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг СХНЭ-ийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, заагдсан журмын дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн. 3. УАУЭСК төвийг СХД-ийн 15 дугаар хороонд байрлах эмнэлгийн гадна засвар, дулааны шугам солих засварын ажлыг бүрэн дуусгасан. Харин дотор заслын ажил төсөв санхүүгийн асуудлаас шалтгаалан түр зогссон байна. 4. УАУЭСК төвийг СХНЭ-ийн бүтцэд нэгтгэн холбоотой салбар эмнэлэг, сувиллын орон тоог СХНЭ – ийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн 2025 оны 08 дугаар тогтоолоор эмнэлгийн бүтцэд нэмж, орон тоог шинэчлэн баталсан. 5. УАУЭСК төвийн данс болон төсвийг СХНЭ-т шилжүүлэх хүсэлтийг Сангийн яам, Эрүүл мэндийн яамд уламжлан УАУЭСК төвийн албан хаагчдад 2025 оны 04, 05, 06 дугаар сарын цалин болон илүү цагийн хөлсийг нөхөж олгосон. 6. Тус клиник төвийн 101 албан хаагчдад “Сонсох ажиллагааны мэдэгдэл”-ийг хүргүүлэн, 3 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Үүнээс үргэлжүүлэн ажиллах хүсэлт өгсөн 33 албан хаагчтай Хөдөлмөрийн гэрээг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байгуулан ажилласан. Мөн	
--	--	--	--	--	---	--

						тэтгэвэрт гарсан 2, ажлаас гарах өргөдөл өгсөн 54 албан хаагч байгаа бол хүүхэд асрах чөлөөтэй 6 албан хаагч байна.	
59	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлд:	1	94	Өргөдөл, гомдол гаргасан иргэдийг шийдвэрлэлтийн явц болон шийдвэрлэсэн тухай мэдээллээр хангаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байгаа иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээний агуулга, боловсруулалтын чанарыг сайжруулах, иргэдээс удаа дараа гаргаж байгаа гомдлын шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлж, түүнийг бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тусгаж ирүүлэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт	Байгууллагын хамт олны 2 удаагийн хурлаар өргөдөл гомдлын явц, зөрчлийн мэдээллийн танилцуулга хийж, зөрчил гаргасан мэргэжилтэн, хэлтсийн дарга нарт сануулж, гомдлын хугацаа дуусах өргөдлийг мэргэжилтэн тус бүрээр биечлэн цахим сүлжээгээр сануулан ажиллаж байна. Хэлтсийн болон мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өргөдөл гомдлын шийдвэрлэлт, дундаж хугацаа, зөрчлийг тусгуулан хагас жилийн үнэлгээгээр хэлтэс тус бүрийн дундаж хугацаа эрс буурсан.	100
		2	95	2.Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад хамгийн их зөрчил гаргасан Сүхбаатар, Баянгол, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг (харьяа байгууллагууд)-үүд, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хяналт, шалгалтын газар, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Геодези, усны барилга, байгууламжийн газруудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллахыг дээрх байгууллагын удирдлага нарт;	байгууллагын удирдлага нарт	НЗДТГ-аас ирүүлсэн “Чиглэл хүргүүлэх тухай” 03/4008 дугаартай албан бичигт дурьдсан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад удаа дараа зөрчил гаргасан албан тушаалтан, албан хаагчдад хариуцлага тооцох чиглэлийн дагуу хэлтсийн дарга нар болон ахлах мэргэжилтнүүдийн өргөтгөсөн хурлыг хийж, 1 дүгээр улирал болон 2 дугаар улирлын байдлаар хэлтэс тус бүрээр хэлэлцэн удаа дараа зөрчилд орсон албан хаагчдад хурлын тэмдэглэлээр сануулга өгч ажилласан.	100
		4	97	4.Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн	байгууллагын удирдлага нарт	НЗДТГ-аас ирүүлсэн “Чиглэл хүргүүлэх тухай” 03/4008 дугаартай	100

				Хяналт Шалгалтын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газар, Баянгол дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Мал эмнэлгийн газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллахыг дээрх байгууллагын удирдлага нарт;		албан бичигт дурьдсан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад хугацаа хэтрүүлэн зөрчил гаргасан албан тушаалтан, албан хаагчдад хариуцлага тооцох чиглэлийн дагуу хэлтсийн дарга нар болон ахлах мэргэжилтнүүдийн өргөтгөсөн хурлыг хийж, 1 дүгээр улирал болон 2 дугаар улирлын байдлаар хэлтэс тус бүрээр хэлэлцэн удаа дараа зөрчилд орсон албан хаагчдад хурлын тэмдэглэлээр сануулга өгч ажилласан.	
		5	98	5.Цаашид иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэхгүй байх, өргөдөл, гомдол шийдвэрлэх явцад зөрчил гаргахгүй, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнаж ажиллахад анхаарч, 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар дээрх зөрчил дутагдлыг гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцсон тухай мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт	НЗДТГ-аас ирүүлсэн “Чиглэл хүргүүлэх тухай” 03/4008 дугаартай албан бичигт дурьдсан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад удаа дараа зөрчил гаргасан албан тушаалтан, албан хаагчдад хариуцлага тооцох чиглэлийн дагуу хэлтсийн дарга нар болон ахлах мэргэжилтнүүдийн өргөтгөсөн хурлыг хийж, 1 дүгээр улирал болон 2 дугаар улирлын байдлаар хэлтэс тус бүрээр хэлэлцэн удаа дараа зөрчилд орсон албан хаагчдад хурлын тэмдэглэлээр сануулга өгч ажилласан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 7 хоног бүр хүргүүлэн ажиллаж байна.	100
76	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар хуралдааны тэмдэглэлд:	1	124	“Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэгт нэгтгэн өөрчлөн байгуулах талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар,	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Нийслэлийн Засаг Даргын 2025 оны “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэгтгэсэнтэй холбоотой авах зарим арга хэмжээ тухай” А/824 дүгээр захирамжийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төвийн	100

				орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч (А.Амартүвшин)-д үүрэг болгов.” гэжээ.		бүртгэлтэй эд хөрөнгийг Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн балансаас балансад шилжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран тус дүүргийн УАУЭСК төв болон Хан-Уул дүүргийн “Богд-Уул” сувиллын эд хөрөнгийг тоолж бүртгэх ажлыг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр бүрэн дуусгасан. 2. Актлах шаардлагатай хөрөнгө болон балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг СХНЭ-ийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, заагдсан журмын дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн. 3. УАУЭСК төвийг СХНЭ-ийн бүтцэд нэгтгэн холбоотой салбар эмнэлэг, сувиллын орон тоог СХНЭ – ийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн 2025 оны 08 дугаар тогтоолоор эмнэлгийн бүтцэд нэмж, орон тоог шинэчлэн баталсан.	
77	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар хуралдааны тэмдэглэлд:	1	125	1.Нийслэлийн Эрүүл мэндийн газрын бүтцийн өөрчлөлтийг хийж нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар танилцуулахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Х.Бат-Ирээдүй);	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1116 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрэмд байгууллагын үндсэн чиг үүргийг заасан ба НЭМГ-ын даргын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Албан хаагчийг шилжүүлэн томилох тухай” А/286 дугаар тушаалаар 110 орон тоог баталж байгуулсан.	100

		2	126	2.Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн үйл ажиллагааг зогсоож, Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэгт нэгтгэн тус төвийн уламжлалыг хадгалан тухайн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулах, засварын ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Х.Бат-Ирээдүй);	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Нийслэлийн Засаг Даргын 2025 оны “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэгтгэсэнтэй холбоотой авах зарим арга хэмжээ тухай” А/824 дүгээр захирамжийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. УАУЭСК төвийн данс болон төсвийг СХНЭ-т шилжүүлэх хүсэлтийг Сангийн яам, Эрүүл мэндийн яамд уламжлан УАУЭСК төвийн албан хаагчдад 2025 оны 04, 05, 06 дугаар сарын цалин болон илүү цагийн хөлсийг нөхөж олгосон. Тус клиник төвийн 101 албан хаагчдад “Сонсох ажиллагааны мэдэгдэл”-ийг хүргүүлэн, 3 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Үүнээс үргэлжүүлэн ажиллах хүсэлт өгсөн 33 албан хаагчтай Хөдөлмөрийн гэрээг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байгуулан ажилласан. Мөн тэтгэвэрт гарсан 2, ажлаас гарах өргөдөл өгсөн 54 албан хаагч байгаа бол хүүхэд асрах чөлөөтэй 6 албан хаагч байна. Мөн УАУЭСК төвийг СХД-ийн 15 дугаар хороонд байрлах эмнэлгийн гадна засвар, дулааны шугам солих засварын ажлыг бүрэн дуусгасан. Харин дотор заслын ажил төсөв санхүүгийн асуудлаас шалтгаалан түр зогссон байна.	100
130	Нийслэлийн засаг даргын зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд;	1	200	1.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн хуралдаан болон намын бүлгүүд, Хороодын хуралд өргөн мэдүүлж байгаа асуудлыг хэлэлцэхэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүх шатны удирдлагууд холбогдох бэлтгэлээ хангаж, биечлэн	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүх шатны удирдлагууд	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Хороодын хуралд өргөн мэдүүлж байгаа асуудлыг хэлэлцэхэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүх шатны удирдлагууд холбогдох бэлтгэлээ хангаж, биечлэн	100

				оролцох, хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцож ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т;		оролцох, хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцож ажиллахыг тус газрын нийт албан хаагчдад 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр танилцуулан ажилласан.	
131	Нийслэлийн засаг даргын зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд:	1	204	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн хуралдаан болон намын бүлгүүд, Хороодын хуралд өргөн мэдүүлж байгаа асуудлыг хэлэлцэхэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүх шатны удирдлагууд холбогдох бэлтгэлээ хангаж, биечлэн оролцох, хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцож ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т үүрэг болгов." гэжээ.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Хороодын хуралд өргөн мэдүүлж байгаа асуудлыг хэлэлцэхэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүх шатны удирдлагууд холбогдох бэлтгэлээ хангаж, биечлэн оролцох, хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцож ажиллахыг тус газрын нийт албан хаагчдад 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр танилцуулан ажилласан.	

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

У.БАТ-ОЧИР

ТАСГИЙН ДАРГА

Д. Нарантуул



Д.НАРАНТУУЛ

ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.Хоролсүрэн

М.ХОРОЛСҮРЭН